# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн албаны тухай хууль 2019.01.01 |
| Дагаж мөрдөх огноо: | 2019.01.11 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2021.02.01 |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: Биеийн тамир, спортын газар | Нэгжийн нэр: Спорт, сургалт, дасгалжуулалтын алба |
| Албан тушаалын нэр: Хөнгөн атлетикийн дасгалжуулагч | Албан тушаалын ангилал, зэрэглэл: ТҮ-6 |
| Ажлын цаг: 8 цаг | Ажлын байрны албан ёсны байршил: Хэрлэн сум, 10 дугаар баг, Биеийн тамир спортын газар |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр, бодлого, чиглэл, зорилго зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, спортыг хөгжүүлэх, тамирчдын ур чадвар, амжилтыг бүс, улс, тив, дэлхийн түвшинд хүргэх, багш дасгалжуулагчдыг мэргэжил, арга зүйгээр хангаж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх.

**Албан тушаалын зорилт:**

1.Монгол улсын Засгийн газар, Боловсрол соёл,шинжлэх ухаан спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн Засаг даргаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах.

2 Хөнгөн атлетикийн спортын өсвөрийн шигшээ багийн сургалт, дасгалжуулалтыг удирдан зохион байгуулж, багш дасгалжуулагчдыг мэргэжлийн арга зүйгээр хангах.

3.Нийтийн биеийн тамирыг сурталчлах, хөгжүүлэх, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд биеийн тамирын дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах.

4.Аймгийн Биеийн тамир, Спортын газрын Хөнгөн атлетикийн заал талбай тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | **Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г** Хянах – **Х** Шийдвэрлэх-**Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, мэргэжлийн байгууллагаас гаргасан зорилго зорилт, бодлого шийдвэр, Аймгийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх.<br>2.Спортын төрлүүдийг орон нутагт хөгжүүлэхэд шаардлагатай бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, тогтоол шийдвэр гаргуулах саналыг удирдлага болон ахлах дасгалжуулагчид уламжлах.<br>4. Аймаг, сумын албан байгууллага, аж ахуй нэгж, албан хаагчдад мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр туслалцаа үзүүлэн хамтран ажиллах.<br>5. Хөнгөн атлетикийн өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтыг удирдан зохион байгуулах, бүс, улс, олон улсын тэмцээнд оролцуулах, хамтарсан бэлтгэл цугларалт зохион байгуулах. | Батлагдсан хөтөлбөрийн шийдвэрийг хэрэгжүүлнэ | Г,Т |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Хөнгөн атлетикийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын анкет боловсруулах, бие бялдарын түвшин тогтоох сорил авах, дүгнэлт хийх.<br>2.Иргэд, аж ахуй нэгжүүдтэй Хөнгөн атлетикийн спортыг сурталчлан таниулах ажлыг хамтран зохион байгуулж, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх.<br>3.Хариуцсан спортын төрлөөр дасгалжуулагчдын зөвлөл байгуулж хууль эрх зүйн болон мэдлэг, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах.<br>4.Жилийн ажлын тайланг 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж ахлах дасгалжуулагчаар дүгнүүлэх. | Мэргэжлийн арга зүйгээр хангана | Г,Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Хариуцсан албан байгууллагуудынхаа орон тооны бус арга зүйч, биеийн тамирын багш нартай хамтран зөвлөл байгуулж, үр дүнд хүрсэн байх.<br>2.Багийн иргэд болон зорилтот бүлгүүдийн дунд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах, шинийг санаачлагч ,бүтээлч байх | Нийтийн биеийн тамирын арга зүйгээр хангана | Г,Т |

| | | | |
|---|---|---|---|
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Байгууллагын Хөнгөн атлетикийн заалын аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хангах.<br>2.Спортын ордонд зохион байгуулагдах арга хэмжээний тоног төхөөрөмж, хэрэглэл материалын бэлэн байдлыг хангах. | Өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангана | Г,Т |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | Бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй | |
| **Мэргэжил** | Багш дасгалжуулагч | |
| **Мэргэшил** | Спортын болон шүүгчийн цол, зэрэгтэй байх | |
| **Туршлага** | Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх | |
| **Ур чадвар** | Удирдан зохион байгуулах | -Спортын олон талын мэдлэгтэй байх.<br>-Төлөвлөх, тайлагнах, салбарын болон байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийн онол арга зүйг эзэмшсэн. |
| | Дүн шинжилгээ хийх | -Бэлтгэл сургуулилтын график төлөвлөгөөг гаргах, батлуулах<br>-Зохион байгуулагдсан спортын арга хэмжээ болон оролцсон уралдаан тэмцээний дүн тайлан гаргах<br>-Үйл ажиллагааны тайлан, үнэн зөв гаргах, дүн шинжилгээ хийх чадвартай.<br>-Сум, албан байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын спортын арга хэмжээний тайлан мэдээг авч нэгтгэх |
| | Асуудал шийдвэрлэх | -Шийдвэр, хууль, тогтоомжийг болон үйлчлүүлэгч байгууллага, албан тушаалтан, иргэдийн эрх ашигт нийцүүлэх чадвар төлөвшилтэй байх.<br>-Зохион байгууллагдаж байгаа үйл ажиллагааг үнэн бодитой мэдээлэлд үндэслэн зөв үнэлж дүгнэх. |
| | Манлайлах | -Ёс зүйгээр манлайлан үлгэр дууриал үзүүлэх<br>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах<br>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх<br>-Төрийн албаны ёс зүйн хэмжээг хүндэтгэн сахих чадвар төлөвшилтэй.<br>-Багаар ажиллах чадвартай байх. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:<br>Биеийн тамир, спортын газрын дарга | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>- | Бусад харилцах субъект<br>1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам<br>2.Аймгийн Засаг даргын Тамгын газар<br>3.Сумдын Засаг даргын Тамгын газар<br>4.Аж ахуйн нэгж<br>5.Албан байгууллагууд<br>6.Иргэд |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
| --- | --- |
| Албан тушаал:Хүний нөөцийн мэргэжилтэн<br>............. /Б.Саранзаяа/<br>(Гарын үсэг)<br>2021 оны 02дугаар сарын 01 -ны өдөр | Байгууллагын нэр:Биеийн тамир, спортын газар<br>Шийдвэрийн огноо..2021.02.01<br>Дугаар: ............... |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгуулгын нэр:Биеийн тамир, спортын газар
Шийдвэрийн огноо. 2021 оны 02дугаар сарын 01.-ны өдөр
Дугаар: ...........
(тамга/тэмдэг)
..................../Б.Чимэддорж/
(Гарын үсэг)
2021 оны 02дугаар сарын 01.-ны өдөр